III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй.
Мэргэжил	- Бизнесийн удирдлага /0413/ - Санхүүгийн удирдлага /0413/ - Эрх зүйч / 0421/
Мэргэшил	- Стратеги төлөвлөлт, бизнес хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, санхүүгийн шинжилгээ болон төлөвлөлтийн талаар туршлагатай байх - Олон улсын хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээрийн суурь ойлголттой, хий дамжуулах хоолойн төслийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно

Туршлага	- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай	
Ур чадвар	Асуудал шийдвэрлэх	- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, эрсдэлийг тооцох, хариуцах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг гаргах; - албан тушаалын чиг үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, харилцааг бий болгох; - маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх; - багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах; - бүтээлч санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - бусад
	Бусад	- аль нэг гадаад хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээлэл өгөх; - байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх.

IV.ЭРХ ХЭМЖЭЭ, ШИЙДВЭР ГАРГАЛТ, ХАРИУЦЛАГА

Эрх хэмжээ:	Үүрэг хариуцлага:
1.Өөрийн хариуцсан ажлын хүрээнд холбогдох санал гаргах; 2.Компанийн дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчилд сахилгын арга хэмжээг авах санал оруулах; 3.Компанийн удирдлагад санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх; 4.Хөдөлмөрийн гэрээ, холбогдох шийдвэрт заасны дагуу өөрийн ажлын бүтээмжид тохирсон цалин хөлс, шагнал урамшуулал авах.	1.Ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажил үүргийг шууд удирдлагын заавар, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэн ажиллана. 2.Ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн болон зөрчил дутагдал гаргасан тохиолдолд холбогдох хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл хүлээнэ. 3.Компанийн дүрэм журмыг мөрдөж ажиллаагүйгээс байгууллагад хохирол учирсан тохиолдолд зохих хариуцлага хүлээнэ. 4.Ажлын зохион байгуулалтын буруугаас төлөвлөсөн ажил хугацаандаа эхлээгүй, ажил эхлэхэд шаардлагатай арга хэмжээнүүд урьдчилан хийгдээгүй тохиолдолд зохих хариуцлага хүлээнэ. 5.Компанид ажиллаж байх хугацаандаа ажил хэргийн

	шугамаар олж авсан, хууль тогтоомжоор нууцалсан мэдээлэл мөн ажилтнуудтай холбоотой хувийн болон албан мэдээллүүд нь байгууллагын нууцад хамаарах бөгөөд хадгалж хамгаалах үүргээ зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ; 7.Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолттой танилцсан ажилтан:
Албан тушаал: Хууль, хүний нөөцийн хэлтсийн дарга: ...../Г.Оюун/ 2026 оны ..... сар .....өдөр	Албан тушаал Стратеги, төлөвлөлтийн мэргэжилтэн ...../ ...../ 2026 оны ..... сар .....өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянасан:

Захиргаа удирдлагын газрын дарга:

...../Т.Батбилэг/

2026 оны ..... сар .....өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: "ЭРДЭНЭС ГАЗ" ХХК

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....

(тамга/тэмдэг)

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ /П.БАТАА/

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

"Эрдэнэс Газ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны 02 сарын 16 өдрийн 03 дугаар
тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ
GAS
ЭРДЭНЭС ГАЗ
ХХК
9026030560 ж 6162401

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
"Эрдэнэс Газ" ХХК	Стратеги, санхүү удирдлагын газар
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Стратеги, төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн	
Шууд удирдлага:	Орлон болон хавсран ажиллах:
Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга	
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	Хамаарахгүй
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
Ажлын өдөр 8 цаг	Монгол Улс, Улаанбаатар хот 14240 Сүхбаатар дүүрэг 1-р хороо, С.Жамъян Гүнгийн гудамж, 8-р байр, 301-3

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Компанийн урт болон дунд хугацааны стратеги, бизнесийн зорилго, зорилтуудыг төлөвлөх, тодорхойлох, хөгжүүлэх, хэрэгжилтийг хянах үйл ажиллагаанд туслах, холбогдох судалгаа, шинжилгээ, мэдээ, мэдээлэл, материалыг нэгтгэх, боловсруулалт хийх;
Санхүү, үнэлгээ, шинжилгээ болон төсөвлөлтийн талаарх мэдээллийг нэгтгэн, боловсруулж, холбогдох удирдлагад хүргүүлэх;

Албан тушаалын зорилт:

1. Компанийн стратеги төлөвлөлт, бодлогод суурилсан төсвийн төслийг бэлтгэх, саналыг нэгтгэх, нэгтгэсэн санал дээр боловсруулалт хийх;
2. Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах, компанийн тухайн жилийн үйл ажиллагааны болон бизнесийн төлөвлөгөөг боловсруулахад туслах, санал оруулах, шаардлагатай судалгаа, мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэж боловсруулах;
3. Олон улсын сайн туршлага, харилцагч байгууллагуудын эрэлт хэрэгцээг судалсан судалгааны үндсэн дээр урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах, танилцуулах, батлуулах, хэрэгжилтийг хянах, үнэлэхэд туслах, холбогдох ажлуудыг төлөвлөх, хийж гүйцэтгэх;
4. Компани болон нэгжийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх, хууль эрх зүй болон бусад эрсдэлийг тодорхойлж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах–Х Шийдвэрлэх –Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Компанийн стратеги төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай үйл ажиллагааны болон эдийн засгийн судалгааг цаг тухай бүр хийх, хянах, нэгжийн удирдлагыг мэдээллээр хангах;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Г
	2. Бизнес төлөвлөгөөний санхүүгийн төлөвлөлттэй холбоотой жилийн төсвийн төслийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан боловсруулахад дэмжлэг үзүүлэх, эрсдэлийг хянах;	Хугацаа, чанарын зөрчилгүй хэрэгжилт	Г
	3. Компанийн санхүүгийн чадварт хийсэн үнэлгээ, шинжилгээ, санхүүгийн харьцаа үзүүлэлтийн тооцоолол хийх;	Хугацаа, чанарын зөрчилгүй хэрэгжилт	Г
	4. Компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг зохистой төвшинд хадгалах, сайжруулах чиглэлээр санал боловсруулж, нэгжийн удирдлагыг мэдээллээр хангах, танилцуулах;	Хугацаа, чанарын зөрчилгүй хэрэгжилт	Г
	5. Толгой компани болон түүний харьяа компаниудтай уялдаатай ажиллаж тэдгээрийн эрэлт, хэрэгцээг мэдэрч, бизнесийн үйл ажиллагаа, бизнес хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх, зорилтот үр дүнд хүрэхийг зорьж, үр ашгийн гүйцэтгэлийг эргэн нягталж, тайланг цаг хугацаанд нь боловсруулж гаргах;	Ажлын уялдаа сайжирсан байдал, хугацаанд хүргэлт	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргах, өөрчлөлт оруулах, холбогдох байгууллагад мэдээлэх, удирдлагад танилцуулах	Төсөв, нөөцийн ашиглалтын үр ашиг	Т, Г

	2. Компанийн дотоод мэдээллийг автоматжуулах, шинээр нэмэлт тайлангуудыг хөгжүүлэх, тоон мэдээллийн тайлагналын үйл ажиллагааг хөгжүүлэх талаар санал боловсруулах;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Г
	3. Төсөл хэрэгжихэд учирч болох эрсдэлүүдийг тодорхойлж, нөлөөлөх хүч, тохиолдох магадлалыг тодорхойлж эрсдэлээс зайлсхийх төлөвлөгөөг гаргах;	Эрсдэлийн бууралтын түвшин, урьдчилан сэргийлэлт	Г, Х
	4. Стратеги төлөвлөгөөтэй уялдуулан жилийн зорилго, зорилтыг тодорхойлох, холбогдох газруудаас мэдээллийг цуглуулах, нэгтгэх, ажлын нэгдсэн төлөвлөгөөг бэлтгэх;	Ажлын уялдаа сайжирсан байдал, үр ашиг	Г
	5. Стратеги, жилийн төлөвлөгөөг гардан гүйцэтгэх, хуваарилах, нэгжүүдэд сурталчлан таниулах, нэгжүүдийг чиглүүлэх, хянах;	Биелэлт, хугацааны хоцрогдол	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Гадаад болон дотоод орчны шинжилгээнд тулгуурлан 5 жилийн зорилго, зорилтыг тодорхойлох;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Г
	2. Компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөөг батлуулах, сурталчлах;	Тайлангийн чанар, хугацаа, шийдвэрт ашиглагдсан байдал	Г
	3. Зорилго, зорилтод хүрэх үе шатуудыг тодорхойлох, хийгдэх (ахиц дэвшил гаргах, томоохон) ажлын төлөвлөгөөг боловсруулах;	Биелэлт, хугацааны хоцрогдол	Г
	4. Жил бүр стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргаж, компанийн жилийн болон хагас жилийн тайланг бэлтгэн холбогдогч талуудад хүргүүлэх;	Тайлангийн чанар, хугацаа, шийдвэрт ашиглагдсан байдал	Г
	5. Санхүүгийн төлөвлөгөөг бэлтгэх, санал оруулах, хянах; – Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (Хөрөнгө оруулалтын тооцооллын хамт) – Мөнгөн урсгалын төлөвлөгөө – Орлого, үр дүнгийн төлөвлөгөө;	Тайлангийн чанар, хугацаа, шийдвэрт ашиглагдсан байдал	Т
	6. Орчны шинжилгээг хийх; - Дотоод орчны шинжилгээ (SWOT, PORTER 5 FORCES гэх мэт) хийх	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Г

	- Улс төр, эдийн засаг, технологи зэрэг гадаад орчны шинжилгээг хийх - Зах зээлийн багтаамж, харилцагчийн эрэлт хэрэгцээг судлах		
	7. Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянах, гүйцэтгэлийн нэгдсэн тайланг сар, улирал болон жилээр нэгтгэж удирдлагад хүргүүлэх;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Г
	8. Санхүүгийн төлөвлөгөөг дэлгэрэнгүй байдлаар боловсруулах; - Орлогын дэлгэрэнгүй тайлан - Зардлын тайлан - Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, танилцуулга - Санхүү байдлын тайлан;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Үйл ажиллагаандаа компанийн тухай хууль, бусад холбогдох журам, зааврууд болон бусад холбогдох хууль, бодлого, дүрэм, журам, зааврыг мөрдөн ажиллах;	Биелэлт, хугацааны хоцрогдол	Г
	2. Стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, түүний биелэлт, танилцуулга, бусад мэдээ мэдээлэл боловсруулах;	Тайлангийн чанар, хугацаа, шийдвэрт ашиглагдсан байдал	Г,Х
	3. Компанийн удирдлага болон нийт албан хаагчдад эрхэлсэн асуудлын хүрээнд хариуцан ажиллаж буй чиг үүрэгтэй холбоотой асуудлаар мэргэжлийн дэмжлэг туслалцаа, зөвлөмж зөвлөгөөг өгөх, шаардлагатай мэдээллээр ханган ажиллах;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Т, Г
	4. Батлагдсан худалдан авалтын төлөвлөгөөний дагуу, хууль тогтоомжийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах;	Хугацаа, чанарын зөрчилгүй хэрэгжилт	Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй.
Мэргэжил	- Хөгжлийн бодлого менежмент /0413/ - Бизнесийн удирдлага /0413/ - Маркетинг /0414/ - Эдийн засагч /0311/
Мэргэшил	- Олон улсын хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээрийн суурь ойлголттой, хий дамжуулах хоолойн төслийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно

	- Эдийн засаг санхүүгийн салбарт мэргэшсэн байх.	
Туршлага	- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил удирдах албан тушаал хашсан туршлагатай.	
Ур чадвар	Асуудал шийдвэрлэх	- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, эрсдэлийг тооцох, хариуцах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг гаргах; - албан тушаалын чиг үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, харилцааг бий болгох; - маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх; - багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах; - бүтээлч санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - бусад.
	Бусад	- аль нэг гадаад хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээлэл өгөх; - байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх.

IV.ЭРХ ХЭМЖЭЭ, ШИЙДВЭР ГАРГАЛТ, ХАРИУЦЛАГА

Эрх хэмжээ:	Үүрэг хариуцлага:
1.Өөрийн хариуцсан ажлын хүрээнд холбогдох санал гаргах; 2.Компанийн дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчилд сахилгын арга хэмжээг авах санал оруулах; 3.Компанийн удирдлагад санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх; 4.Хөдөлмөрийн гэрээ, холбогдох шийдвэрт заасны дагуу өөрийн ажлын бүтээмжид тохирсон цалин хөлс, шагнал урамшуулал авах.	1.Ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажил үүргийг шууд удирдлагын заавар, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэн ажиллана. 2.Ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн болон зөрчил дутагдал гаргасан тохиолдолд холбогдох хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл хүлээнэ. 3.Компанийн дүрэм журмыг мөрдөж ажиллаагүйгээс байгууллагад хохирол учирсан тохиолдолд зохих хариуцлага хүлээнэ. 4.Ажлын зохион байгуулалтын буруугаас төлөвлөсөн ажил хугацаандаа эхлээгүй, ажил эхлэхэд шаардлагатай арга хэмжээнүүд урьдчилан хийгдээгүй тохиолдолд зохих хариуцлага хүлээнэ.

	5.Компанид ажиллаж байх хугацаандаа ажил хэргийн шугамаар олж авсан, хууль тогтоомжоор нууцалсан мэдээлэл мөн ажилтнуудтай холбоотой хувийн болон албан мэдээллүүд нь байгууллагын нууцад хамаарах бөгөөд хадгалж хамгаалах үүргээ зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ; 7.Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолттой танилцсан ажилтан:
Албан тушаал: Хууль, хүний нөөцийн хэлтсийн дарга:/Г.Оюун/ ...../...../ 2026 оны ..... сар .....өдөр	Албан тушаал Стратеги, төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн ...../..... / 2026 оны ..... сар .....өдөр
Албан тушаалын тодорхойлолтыг хянасан: Захиргаа, удирдлагын газрын дарга:/.Батбилэг/ ...../...../ 2026 оны ..... сар .....өдөр	
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: "ЭРДЭНЭС ГАЗ" ХХК Шийдвэрийн огноо: ..... Дугаар: ..... (тамга/тэмдэг) ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ /П.БАТАА/ 2026 оны ... дугаар сарын ... ны өдөр	

“Эрдэнэс Газ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны ...сарын ...өдрийн ...дугаар
тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Эрдэнэс Газ ХХК	Стратеги, санхүү удирдлагын газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга	
Шууд удирдлага:	**Орлон болон хавсран ажиллах:**
Стратеги, Санхүү удирдлагын газрын дарга	
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдөр 8 цаг	Монгол Улс, Улаанбаатар хот 14240 Сүхбаатар дүүрэг 1-р хороо, С.Жамъян Гүнгийн гудамж, 8-р байр, 301-3

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Компанийн урт болон дунд хугацааны стратеги мөн зорилго, зорилтуудыг тодорхойлон хөгжүүлэх, төлөвлөх, хэрэгжилтийг хянах, тайлагнах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх. Санхүүгийн үйл ажиллагааны үнэлгээ, шинжилгээ болон төсөвлөлтийн талаар гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах материалыг бэлтгэн хянуулах. Компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тогтвортой хөгжих боломжоор хангаж ажиллах.

Албан тушаалын зорилт:

1. Компанийн стратеги төлөвлөлт, бодлогод суурилсан санхүүгийн төсвийн төслийг боловсруулах, санхүүгийн чадварт үнэлгээ, шинжилгээ хийж, санхүүгийн чадварыг хадгалах, сайжруулах чиглэлээр холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэх;
2. Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах, компанийн тухайн жилийн үйл ажиллагааны болон бизнесийн төлөвлөгөөг боловсруулах, санхүүгийн тайлангийн төсөөлөл боловсруулах, холбогдох санал оруулах;
3. Өнөөгийн нөхцөл байдал (гадаад болон дотоод орчин), олон улсын сайн туршлага, харилцагч байгууллагуудын эрэлт хэрэгцээг судалсны үндсэн дээр урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах, танилцуулах, батлуулах, хэрэгжилтийг хянах, үнэлэх, тайлагнах.
4. Компанийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хэлтсийн үйл ажиллагааны хэвийн тасралтгүй, найдвартай байдлыг хангахад төлөвлөлт, шинжилгээний ажлыг гүйцэтгэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах–Х Шийдвэрлэх –Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Компанийн стратеги төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай эдийн засгийн судалгааг цаг тухай бүр шуурхай хийх, нэгжийн удирдлагыг мэдээллээр хангах;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Г, Х
	2. Бизнес төлөвлөгөөний санхүүгийн төлөвлөлттэй холбоотой жилийн төсвийн төслийг холбогдох хууль, дүрэм журмын дагуу үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан боловсруулах;	Хугацаа, чанарын зөрчилгүй хэрэгжилт	Г, Х
	3. Компанийн санхүүгийн чадварт үнэлгээ, шинжилгээ хийж, санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдийн тооцоолол хийх;	Хугацаа, чанарын зөрчилгүй хэрэгжилт	Т, Х
	4. Компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг зохистой төвшинд хадгалах, сайжруулах чиглэлээр санал боловсруулж, нэгжийн удирдлагыг мэдээллээр хангах, танилцуулах, батлуулах, хэрэгжилтийг хянах;	Хугацаа, чанарын зөрчилгүй хэрэгжилт	Т, Х

	5. Толгой компани болон түүний харьяа компаниудтай уялдаатай ажиллаж тэдгээрийн эрэлт, хэрэгцээг мэдэрч, бизнесийн үйл ажиллагаа, бизнес хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх, зорилтот үр дүнд хүрэхийг зорьж, үр ашгийн гүйцэтгэлийг эргэн нягталж, тайланг цаг хугацаанд нь боловсруулж гаргах;	Ажлын уялдаа сайжирсан байдал, хугацаанд хүргэлт	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Санхүүгийн төлөвлөгөөг бэлтгэх; - Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (хөрөнгө оруулалтын өгөөж тооцооллын хамт) - Мөнгөн урсгалын төлөвлөгөө - Орлого үр дүнгийн төлөвлөгөө	Тайлангийн чанар, хугацаа, шийдвэрт ашиглагдсан байдал	Г, Х
	2. Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргах, гүйцэтгэлийг холбогдох байгууллагад мэдээлэх, өөрчлөлт оруулах, тухай бүр боловсруулан удирдлагад танилцуулах;	Төсөв, нөөцийн ашиглалтын үр ашиг	Г, Х
	3. Компанийн дотоод мэдээллийг автоматжуулах, шинээр нэмэлт тайлангуудыг хөгжүүлэх, тоон мэдээллийн тайлагналын үйл ажиллагааг хөгжүүлэх талаар санал боловсруулах;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Г, Х
	4. Төсөл хэрэгжихэд учирч болох эрсдэлүүдийг тодорхойлж, нөлөөлөх хүч, тохиолдох магадлалыг тодорхойлж эрсдэлээс зайлсхийх төлөвлөгөөг гаргах;	Эрсдэлийн бууралтын түвшин, урьдчилан сэргийлэлт	Г, Х
	5. Стратеги төлөвлөгөөтэй уялдуулан жилийн зорилго, зорилтыг тодорхойлох, хүрэх арга замыг боловсруулах, ажлын нэгдсэн төлөвлөгөөг бэлтгэх;	Ажлын уялдаа сайжирсан байдал, үр ашиг	Г, Х
	6. Компанийн жилийн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хуваарилах, нэгжүүдэд сурталчлан таниулах, нэгжүүдийг чиглүүлэх, хянах;	Биелэлт, хугацааны хоцрогдол	Х
	7. Компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулахтай холбогдуулан газар, хэлтсүүдээс санал авч, нэгтгэн гүйцэтгэлийг удирдлагуудад танилцуулах, батлуулах, сурталчлах;	Тайлангийн чанар, хугацаа, шийдвэрт ашиглагдсан байдал	Г

3 дугаар зорилтын хүрээнд	1. Гадаад болон дотоод орчны шинжилгээнд тулгуурлан дунд болон урт хугацааны зорилго, зорилтыг тодорхойлох;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Г, Х
	2. Компанийн зорилго, зорилтод хүрэх үе шатуудыг тодорхойлох, хийгдэх ажлын (ахиц дэвшил гаргах, томоохон) төлөвлөгөөг боловсруулах;	Биелэлт, хугацааны хоцрогдол	Г, Х
	3. Жил бүр стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргаж, компанийн жилийн болон хагас жилийн тайланг бэлтгэж холбогдогч талуудад хүргүүлэх;	Тайлангийн чанар, хугацаа, шийдвэрт ашиглагдсан байдал	Г, Х
	4. Орчны шинжилгээг хийх; - Дотоод орчны шинжилгээ (SWOT, TOWS) - Улс төр, эдийн засаг, технологи зэрэг гадаад орчны шинжилгээ (PESTLE) - Зах зээлийн багтаамж, харилцагчийн эрэлт хэрэгцээг судлах (PORTER 5 FORCES)	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Т, Х
	5. Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянах, гүйцэтгэлийн нэгдсэн тайланг улирал болон жилээр нэгтгэж удирдлагад хүргүүлэх;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Г, Х
	6. Санхүүгийн төлөвлөгөөг дэлгэрэнгүй байдлаар боловсруулах; - Орлогын дэлгэрэнгүй тайлан - Зардлын тайлан - Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, танилцуулга - Санхүү байдлын тайлан;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Т, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Компанийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээг төлөвлөх, хянах, тайлагнах;	Тайлангийн чанар, хугацаа, шийдвэрт ашиглагдсан байдал	Г, Х
	2. Үйл ажиллагаандаа компанийн тухай хууль, бусад холбогдох журам, зааврууд болон бусад холбогдох хууль, бодлого, дүрэм, журам, зааврыг мөрдөн ажиллах;	Биелэлт, хугацааны хоцрогдол	Г, Х
	3. Компанийн удирдлага болон нийт албан хаагчдад эрхэлсэн асуудлын хүрээнд хариуцан ажиллаж буй чиг үүрэгтэй холбоотой асуудлаар мэргэжлийн дэмжлэг туслалцаа, зөвлөмж зөвлөгөөг өгөх, шаардлагатай мэдээллээр ханган ажиллах;	Мэдээллийн үнэн зөв, хугацаанд хүргэлт	Г, Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй.	
Мэргэжил	- Хөгжлийн бодлого менежмент /0413/ - Бизнесийн удирдлага /0413/ - Маркетинг /0414/ - Эдийн засагч /0311/	
Мэргэшил	- Олон улсын хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээрийн суурь ойлголттой, хий дамжуулах хоолойн төслийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно - Эдийн засаг санхүүгийн салбарт мэргэшсэн байх.	
Туршлага	- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил удирдах албан тушаал хашсан туршлагатай.	
Ур чадвар	Асуудал шийдвэрлэх	- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, эрсдэлийг тооцох, хариуцах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг гаргах; - албан тушаалын чиг үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, харилцааг бий болгох; - маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх; - багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах; - бүтээлч санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - бусад.
	Бусад	- аль нэг гадаад хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээлэл өгөх; - байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх.

IV.ЭРХ ХЭМЖЭЭ, ШИЙДВЭР ГАРГАЛТ, ХАРИУЦЛАГА	
Эрх хэмжээ: 1.Өөрийн хариуцсан ажлын хүрээнд холбогдох санал гаргах; 2.Компанийн дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчилд сахилгын арга хэмжээг авах санал оруулах; 3.Компанийн удирдлагад санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх; 4.Хөдөлмөрийн гэрээ, холбогдох шийдвэрт заасны дагуу өөрийн ажлын бүтээмжид тохирсон цалин хөлс, шагнал урамшуулал авах.	Үүрэг хариуцлага: 1.Ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажил үүргийг шууд удирдлагын заавар, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэн ажиллана. 2.Ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн болон зөрчил дутагдал гаргасан тохиолдолд холбогдох хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл хүлээнэ. 3.Компанийн дүрэм журмыг мөрдөж ажиллаагүйгээс байгууллагад

	хохирол учирсан тохиолдолд зохих хариуцлага хүлээнэ. 4.Ажлын зохион байгуулалтын буруугаас төлөвлөсөн ажил хугацаандаа эхлээгүй, ажил эхлэхэд шаардлагатай арга хэмжээнүүд урьдчилан хийгдээгүй тохиолдолд зохих хариуцлага хүлээнэ. 5.Компанид ажиллаж байх хугацаандаа ажил хэргийн шугамаар олж авсан, хууль тогтоомжоор нууцалсан мэдээлэл мөн ажилтнуудтай холбоотой хувийн болон албан мэдээллүүд нь байгууллагын нууцад хамаарах бөгөөд хадгалж хамгаалах үүргээ зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ; 7.Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолттой танилцсан ажилтан:
Албан тушаал: Хууль, хүний нөөцийн хэлтсийн дарга: ...../Г.Оюун/ 2026 оны ..... сар .....өдөр	Албан тушаал Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга ...../ / 2026 оны ..... сар .....өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянасан:

Захиргаа, удирдлагын газрын дарга:

...../Т.Батбилэг/

2026 оны ..... сар .....өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: "ЭРДЭНЭС ГАЗ" ХХК

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....

(тамга/тэмдэг)

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ /П.БАТАА/

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

“Эрдэнэс Газ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны 04 дүгээр сарын 30 өдрийн Б/34 дугаар
тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ERDENES GAS
ЭРДЭНЭС ГАЗ
ХХК
9026030550 6162401

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Эрдэнэс Газ ХХК	Төслийн удирдлагын газар
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Төслийн хэрэгжилтийн мэргэжилтэн	
Шууд удирдлага:	Орлон болон хавсран ажиллах:
Төслийн судалгаа, хөгжүүлэлтийн хэлтсийн дарга	
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	Хамаарахгүй
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
Ажлын өдөр 8 цаг	Монгол Улс, Улаанбаатар хот 14240 Сүхбаатар дүүрэг 1-р хороо, С.Жамъян Гүнгийн гудамж, 8-р байр, 301-3

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Төслийн судалгаа, хөгжүүлэлтийн хэлтсийн даргын шууд удирдлага дор байгалийн хий дамжуулах хоолойн төслийн болон компанийн төслүүдийн судалгаа, хөгжүүлэлт, дүн шинжилгээ, хөрөнгө оруулалтын үндэслэлийг боловсруулж, төслийн шийдвэр гаргалтад үнэн зөв, бодит мэдээлэл боловсруулахад оршино.

Албан тушаалын зорилт:

1. Төслийн талаарх мэдээлэл цуглуулах, судалгаа шинжилгээ, боловсруулалт хийх;
2. Төслийн гэрээ хэлэлцээртэй холбоотой судалгаа хийж санал боловсруулах;
3. Төслийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих;
4. Газар/хэлтсийн үйл ажиллагааны хэвийн тасралтгүй, найдвартай байдлыг хангаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах–Х Шийдвэрлэх –Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Төслийн мэдээлэл цуглуулах, судалгаа шинжилгээг боловсруулах	Батлагдсан төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь	Г
	2. Судалгаа, шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх;	Судалгааны чанар, хугацаа	Г
	3. Судалгаа шинжилгээний үр дүнг нэгтгэх тайлан боловсруулах;	Тайлангийн чанар, ашиглалт	Г
	4. Судалгаа шинжилгээний хөгжүүлэлтийн ажлын уялдаа холбоог хангах;	Ажлын уялдаа, давхардалгүй байдал	Х
2 дугаар зорилтын хүрээнд	5. Төслийн зах зээлийн чиг хандлагыг судалж, дүн шинжилгээ хийх, боломжуудыг эрэлхийлэх;	Бодлогын саналын чанар	Ш
	6. Хөрөнгө оруулалтын судалгаа шинжилгээ хийх, тайлан боловсруулах;	Судалгааны үндэслэл, тооцооны бодит байдал	Г
	7. Төслийн техник-эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах;	Судалгааны иж бүрэн байдал	Г
	8. Судалгаанд үндэслэн шийдвэр гаргалтыг дэмжих санал гаргах;	Шийдвэрт ашиглагдсан байдал	Г
3 дугаар зорилтын хүрээнд	9. Төслийн хэрэгжилтэд мэргэжлийн зөвлөмж, санал хүргүүлэх;	Зөвлөмжийн хэрэгжилт	Г
	10. Төслийн бараа бүтээгдэхүүний захиалгын тоо хэмжээ, татан авалт, тээвэрлэлтэд хяналт тавих тайлагнах;	Гүйцэтгэлийн түвшин, хоцрогдол (%)	Ш
	11. Төслийн явцын тайлан, мэдээллийг боловсруулах;	Тайлангийн чанар, хугацаа	Г
	12. Төслийн эрсдэлийг тодорхойлох, бууруулах санал боловсруулах;	Эрсдэлийн бууралтын түвшин	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	13. Компанийн болон бусад холбогдох хууль, журам, зааврууд дүрмийг мөрдөн ажиллах;	Гүйцэтгэлийн түвшин, хоцрогдол (%)	Г
	14. Стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, түүний биелэлт, танилцуулга, бусад мэдээ	Гүйцэтгэлийн түвшин, хоцрогдол	Ш

	мэдээлэл боловсруулах, шууд удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэн ажиллах;	(%)	
	15. Газрын үйл ажиллагаатай холбогдох төлөвлөгөө, тогтоол, тушаал шийдвэрийн биелэлтийг хангаж, холбогдох арга хэмжээг авахад санал гаргах;	Тайлангийн чанар, хугацаа	Т
	16. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заагдсан хугацаанд, чанартай, үнэн зөв гүйцэтгэж тайлагнах, удирдлагыг түргэн шуурхай, бодит мэдээллээр хангаж ажиллах;	Даалгаврын биелэлт	Ш
	17. Компанийн бодлогын баримт бичгүүдэд санал хүргүүлэх, хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой батлагдсан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулж ажиллах;	Тайлангийн чанар, хугацаа	Г
	18. Төслийн хэрэгжилтэд мэргэжлийн зөвлөмж, дэмжлэг үзүүлэх;	Хамтын ажиллагааны үр дүн	Г
	19. Төслийн явцын тайлан, мэдээллийг боловсруулах;	Бэлтгэл ажлын чанар	Ш

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	- Үйлдвэрлэлийн эдийн засагч/0413/; - Бизнесийн удирдлага/0413/; - Төслийн менежмент/0413/.	
Мэргэшил	- Хятад хэлний ахисан түвшний мэдлэгтэй, орос хэлний анхан шатны мэдлэгтэй; - Төслийн судалгаа, санхүү, хөрөнгө оруулалтын мэдлэгтэй; - Олон улсын төсөл, хамтын ажиллагааны ойлголттой; - Хий дамжуулах хоолойн төслийн менежментийн чиглэлээр мэргэшсэн.	
Туршлага	- Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажиллаж байсан туршлагатай.	
Ур чадвар	Асуудал шийдвэрлэх	- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, эрсдэлийг тооцох, хариуцах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг гаргах; - албан тушаалын чиг үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч,

		харилцааг бий болгох; - маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх; - багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах; - бүтээлч санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - бусад.
	Бусад	- аль нэг гадаад хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээлэл өгөх; - байгууллагын болон хувь хүний нууц мэдээлэлтэй ажиллах, өндөр хариуцлагатай хадгалах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх.

IV.ЭРХ ХЭМЖЭЭ, ШИЙДВЭР ГАРГАЛТ, ХАРИУЦЛАГА

Эрх хэмжээ: 1.Өөрийн хариуцсан ажлын хүрээнд холбогдох санал гаргах; 2.Компанийн дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчилд сахилгын арга хэмжээг авах санал оруулах; 3.Компанийн удирдлагад санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх; 4.Хөдөлмөрийн гэрээ, холбогдох шийдвэрт заасны дагуу өөрийн ажлын бүтээмжид тохирсон цалин хөлс, шагнал урамшуулал авах.	Үүрэг хариуцлага: 1.Ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажил үүргийг шууд удирдлагын заавар, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэн ажиллана. 2.Ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн болон зөрчил дутагдал гаргасан тохиолдолд холбогдох хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл хүлээнэ. 3.Компанийн дүрэм журмыг мөрдөж ажиллаагүйгээс байгууллагад хохирол учирсан тохиолдолд зохих хариуцлага хүлээнэ. 4.Ажлын зохион байгуулалтын буруугаас төлөвлөсөн ажил хугацаандаа эхлээгүй, ажил эхлэхэд шаардлагатай арга хэмжээнүүд урьдчилан хийгдээгүй тохиолдолд зохих хариуцлага хүлээнэ. 5.Компанид ажиллаж байх хугацаандаа ажил хэргийн шугамаар олж авсан, хууль тогтоомжоор нууцалсан мэдээлэл мөн ажилтнуудтай холбоотой хувийн болон албан мэдээллүүд нь байгууллагын нууцад хамаарах бөгөөд хадгалж хамгаалах үүргээ зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ; 7.Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолттой танилцсан ажилтан:
Албан тушаал: Хууль, хүний нөөцийн хэлтсийн дарга:/Г.Оюун/ ..... 2026 оны ..... сар .....өдөр	Албан тушаал Төслийн хэрэгжилтийн мэргэжилтэн ..... 2026 оны ..... сар .....өдөр
Албан тушаалын тодорхойлолтыг хянасан: Захиргаа удирдлагын газрын дарга:/Т/Батбилэг/ ..... 2026 оны ..... сар ..... өдөр	
Байгууллагын нэр: "ЭРДЭНЭС ГАЗ" ХХК Шийдвэрийн огноо: ..... Дугаар: ..... (тамга/тэмдэг) ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /П.БАТАА/ 2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр	

“Эрдэнэс Газ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны 04 сарын 30-ны өдрийн 04 дугаар
тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
“Эрдэнэс Газ” ХХК	Төслийн удирдлагын газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Төслийн удирдлагын газрын дарга	-
Шууд удирдлага:	**Удирдлагын түвшин:**
Гүйцэтгэх захирал	Гүйцэтгэх захирлын дараах хоёр дахь түвшний удирдлага
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдөр 8 цаг	Монгол Улс, Улаанбаатар хот 14240 Сүхбаатар дүүрэг 1-р хороо, С.Жамъян Гүнгийн гудамж, 8-р байр, 301-3

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор компанийн өдөр тутмын үйл ажиллагааны нэгдсэн уялдаа холбоог гүйцэтгэх захирлын дараах хоёр дах түвшний удирдлагын хэмжээнд хангах, нэгдлийн стратеги төлөвлөгөө, бодлого, дүрэм журмуудын дагуу компанийн хэрэгжүүлж буй байгалийн хий дамжуулах хоолойн төсөл болон бусад төслүүдийн төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт, хяналт, хамтын ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, төслүүдийн үр дүнг компанийн болон үндэсний эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэхэд оршино.

Албан тушаалын зорилт:

1. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааны нэгдсэн уялдаа болон байгалийн хий дамжуулах хоолойн төслийн стратеги, төлөвлөлт, хэрэгжилтийг удирдах;
2. Төслийг барилга угсралтын шатанд шилжүүлэх бэлтгэл, техникийн шийдэл, зөвшөөрөл, чанар, аюулгүй ажиллагааны уялдааг хангах;
3. Газпром, CNPC, төрийн байгууллага болон бусад оролцогч талтай хэрэгжүүлэх олон улсын хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээр, хөрөнгө оруулалт болон дотоодын хийн асуудлаарх шийдвэрийн бэлтгэлийг хангах;
4. Төслийн гүйцэтгэл, өөрчлөлт, эрсдэл, нийцэл, тайлагнал болон мэдээллийн удирдлагыг хэрэгжүүлэх;
5. Төслийн удирдлагын газрын манлайлал, хүний нөөцийн гүйцэтгэл, мэргэжлийн чадавх, мэдлэгийн тогтолцоог хөгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	**Хариуцлага, оролцооны хэлбэр** Туслах–Т, Гүйцэтгэх–Г, Хянах–Х, Шийдвэрлэх–Ш, Санал оруулах–С
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Гүйцэтгэх захирлын тогтоосон бодлого, чиглэл, эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааны нэгдсэн уялдааг хангах;	Удирдлагын шийдвэрийн хэрэгжилт, нэгж хоорондын саатлын тоо	**Ш**
	2. Компанийн үйл ажиллагаа болон байгалийн хий дамжуулах хоолойн төсөлтэй холбоотой асуудлаар бусад газрын дарга нарт үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах;	Үүрэг даалгаврын хугацаанд хэрэгжсэн хувь	**Ш**
	3. Удирдлагын шуурхай болон өргөтгөсөн хурлын бэлтгэл, асуудлын нэгтгэл, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэх захиралд тайлагнах;	Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн хувь	**Г**
	4. Төслийн судалгаа, хөгжүүлэлтийн хэлтэс болон төслийн хэрэгжилтийн хэлтсийн тэргүүлэх чиглэл, ажлын уялдаа, гүйцэтгэлийг удирдах;	Газрын төлөвлөгөөний биелэлт, нэгжийн гүйцэтгэл	**Ш**
	5. Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн стратеги, засаглалын бүтэц, үе шат, хэрэгжилтийн зарчмыг тодорхойлж, батлуулах;	Батлагдсан стратеги, засаглалын баримт бичгийн бэлэн байдал	**С**
	6. Төслийн удирдлагын нэгдсэн төлөвлөгөө, ажлын задаргааны бүтэц, мастер хуваарь болон суурь төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг удирдах;	Батлагдсан суурь төлөвлөгөө, гол үе шатны биелэлт	**Г**
	7. Төслийн хамрах хүрээ, хугацаа, өртөг, чанар, аюулгүй ажиллагаа, оролцогч тал, харилцаа холбооны удирдлагыг нэгтгэн зохицуулах;	Төслийн үндсэн үзүүлэлтийн хэлбэлзэл, залруулах арга хэмжээ	**Г**
	8. Төслийн үе шатны шалгуур, шийдвэрийн цэг, хүлээлгэн өгөх үр дүнгийн бэлэн байдлыг үнэлж, дараагийн шатанд шилжүүлэх санал боловсруулах;	Үе шатны шалгуур хангасан байдал, шийдвэрийн материалын чанар	**С**

	9. Хуваарь, төслийн төсөвт нөлөөлөх өөрчлөлт, техникийн шийдлийн өөрчлөлтийг үнэлж, шийдвэрлүүлэх саналыг гүйцэтгэх захиралд оруулах;	Саналын үндэслэл, шийдвэрлэгдсэн өөрчлөлтийн хувь	С
	10. Яаралтай болон нэгж хоорондын маргаантай асуудлыг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэж, гүйцэтгэх захиралд асуудлыг шуурхай танилцуулах;	Шийдвэрлэлтийн хугацаа, давтан үүссэн асуудлын тоо	Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, олон нийтийн оролцоо, сонсгол болон холбогдох шийдвэрийг гаргуулах ажлыг удирдан зохицуулах;	БОННҮ болон олон нийтийн оролцооны үе шатны хэрэгжилт	Г
	2. Газрын эрх, кадастр, орон нутгийн зөвшилцөл, барилга угсралтын ажил эхлүүлэхэд шаардлагатай зөвшөөрлийн ажлыг холбогдох нэгж, байгууллагатай уялдуулах;	Зөвшөөрөл, газрын эрхийн бэлэн байдлын хувь	Х
	3. Хоолойн зураг төсөл, барилга угсралт, цахилгаан хангамж болон дагалдах байгууламжийн техникийн ажлын захиалагчийн хяналтыг удирдах;	Техникийн шаардлага хангасан байдал, илэрсэн зөрчлийн шийдвэрлэлт	Х
	4. Чанар, ХАБЭА, стандартын нийцэл болон барилга угсралтын бэлэн байдлыг үнэлж, ажил хүлээн авах, залруулах, түр зогсоох асуудлаар гүйцэтгэх захиралд санал оруулах;	Нийцлийн зөрчил, осол, залруулах арга хэмжээний биелэлт	С
3 дугаар зорилтын хүрээнд	1. Газпром, CNPC, холбогдох яам, агентлаг болон бусад оролцогч талын хамтарсан ажлын хэсэгт компанийн төлөөлөгч, гишүүнээр оролцох;	Ажлын хэсгийн оролцоо, өгсөн үүргийн хэрэгжилт	Г
	2. Олон улсын болон өндөр түвшний уулзалт, хэлэлцээний Монголын талын байр суурь, удирдамж, танилцуулга, ярианы сэдэв, шийдвэрийн төслийг бэлтгүүлэх;	Хэлэлцээний материалын чанар, хугацааны бэлэн байдал	Г
	3. Төслийн үндсэн гэрээний бүтэц, зураглал болон Засгийн газар хоорондын гэрээний төслийг боловсруулах ажлыг чиглүүлж, хэлэлцүүлэх;	Гэрээний зураглал, боловсруулсан төслийн бэлэн байдал	Г

	4. Төслийн бусад гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, протокол, нууцлал болон мэдээлэл солилцооны баримт бичгийг боловсруулах ажлыг уялдуулах;	Баримт бичгийн бүрдэл, эрх зүйн болон агуулгын нийцэл	Х
	5. Гэрээ хэлэлцээр, ажлын хэсэг, уулзалтын шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрүүг арилгуулах;	Шийдвэр, үүргийн хугацаанд хэрэгжсэн хувь	Х
	6. Төслийн санхүүгийн загвар, компанийн хувьцаа эзэмших боломж, санхүүжилтийн бүтэц, оролцооны хувилбарыг холбогдох нэгжтэй хамтран боловсруулахад төслийн удирдлагыг мэдээлэл, чиглэлээр хангах;	Санхүүгийн загвар, оролцооны хувилбарын бэлэн байдал	Г
	7. Монголын талын хөрөнгө оруулалт, хувьцаа эзэмшил болон компанийн оролцооны байр суурийн нэгдсэн саналыг боловсруулж, гүйцэтгэх захиралд танилцуулах;	Шийдвэрийн үндэслэл, танилцуулсан хувилбарын чанар	С
	8. Монгол Улсын байгалийн хийн хэрэглээ, хот суурин газрын хэрэгцээ, боломжит хэмжээ, нийлүүлэлтийн хувилбарын нэгдсэн судалгааг удирдах;	Судалгааны хамрах хүрээ, өгөгдлийн чанар, тайлангийн бэлэн байдал	Г
	9. Дотоодод байгалийн хий авч ашиглах эсэх асуудлаарх бодлого, техникийн болон эдийн засгийн хувилбар, шийдвэрийн материалыг боловсруулж, танилцуулах;	Шийдвэрийн материалын бүрдэл, саналын үндэслэл	С
	10. Гүйцэтгэх захирлын тушаал, итгэмжлэл болон олгосон эрх хэмжээний хүрээнд компанийг төлөөлж, төслийн техникийн, зохион байгуулалтын болон хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурах;	Эрх хэмжээний зөрчилгүй төлөөлөл, баримт бичгийн бүрдэл	Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Төслийн эрсдэлийн бүртгэл, магадлал-нөлөөллийн үнэлгээ, хариу арга хэмжээ, эрт сэрэмжлүүлэх тогтолцоог хөтлүүлж, ноцтой эрсдэлийг удирдлагад шуурхай мэдээлэх;	Эрсдэлийн бүртгэлийн шинэчлэл, өндөр эрсдэлийн бууралт	Х
	2. Төслийн өөрчлөлт, асуудал, хамаарал, шийдвэрийн бүртгэлийг хөтлөж, өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээ болон шийдвэрийн саналыг боловсруулах;	Бүртгэлийн бүрэн байдал, шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Г

	3. Төслийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан, удирдлагын самбар, зөрүүний шинжилгээ, цаашдын төлөвийг тогтмол бэлтгэж, гүйцэтгэх захиралд танилцуулах;	Тайлангийн хугацаа, үнэн зөв байдал, шийдвэрт ашиглагдсан байдал	**Г**
	4. Хууль тогтоомж, компанийн дүрэм, бодлого, аудитын зөвлөмж, баримт бичгийн хяналт, мэдээллийн аюулгүй байдал болон нууцлалын хэрэгжилтийг газрын хэмжээнд хангах;	Нийцлийн зөрчил, аудитын зөвлөмжийн биелэлт	**Х**
	5. Газрын хүний нөөц, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ болон санхүүгийн хэрэгцээг төлөвлөж, төсөв болон худалдан авалтын саналыг эрх бүхий нэгж, гүйцэтгэх захиралд хүргүүлэх;	Нөөцийн төлөвлөлтийн үндэслэл, батлагдсан саналын хэрэгжилт	**С**
5 дугаар зорилтын хүрээнд	1. Газрын ажилтны ажлын зорилго, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, гүйцэтгэлийг үнэлэн, урамшуулал, хөгжүүлэлт, сахилгын арга хэмжээний санал гаргах;	Гүйцэтгэлийн үнэлгээний хугацаа, зорилтын биелэлт	**Ш**
	2. Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн мэргэжлийн сургалт, гадаад туршлага, зөвлөх үйлчилгээ, мэдлэг дамжуулах хөтөлбөрийг төлөвлөж хэрэгжүүлэх;	Сургалт, мэдлэг дамжуулалтын төлөвлөгөөний биелэлт	**Г**
	3. Газрын багийн манлайлал, ёс зүй, хамтын ажиллагаа, хариуцлагатай болон үр дүнд суурилсан соёлыг төлөвшүүлэх;	Ажилтны оролцоо, багийн гүйцэтгэл, ёс зүйн зөрчил	**Ш**
	4. Төслийн баримт бичиг, сургамж, шийдвэр, техникийн болон хэлэлцээний мэдлэгийг байгууллагын мэдлэгийн санд системтэйгээр хадгалж, залгамж чанарыг хангах;	Мэдлэгийн сангийн бүрдэл, шинэчлэл, ашиглалт	**Х**
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	- Олон улсын харилцаа/0312/; - Бизнесийн удирдлага/0412/.		
Мэргэшил	- Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байх; - Олон улсын хамтын ажиллагаа, стратегийн хэлэлцээ, төр-хувийн хэвшлийн уялдаа холбооны мэдлэг, туршлагатай байх; - Орос хэлний ахисан, англи хэлний зохих түвшний мэдлэгтэй.		
Туршлага	- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан; - Удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан.		

Ур чадвар	Манлайлал	- Компанийн стратеги, гүйцэтгэх захирлын шийдвэрийг нэгжийн зорилт болгон хөрвүүлж, хэрэгжилтийг хангуулах; - Компанийн хоёр дахь түвшний удирдлагын хэмжээнд олон нэгжийн үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх; - Тодорхой бус, эрсдэлтэй нөхцөлд үндэслэлтэй байр суурь, шийдвэрийн хувилбар гаргах; - Олон улсын түнш, төрийн байгууллагатай компанийн эрх ашгийг хамгаалан хэлэлцээ хийх; - Өөрчлөлтийг манлайлан, багийн гүйцэтгэл, хариуцлага, залгамж чанарыг хөгжүүлэх.
	Асуудал шийдвэрлэх	- Асуудлын шалтгаан, нөлөөлөл, хувилбар, эрсдэлийг системтэй шинжлэх; - Хугацаа, өртөг, чанар, аюулгүй ажиллагаа болон оролцогч талын ашиг сонирхлыг тэнцвэржүүлсэн санал боловсруулах; - Эрх хэмжээний хязгаарыг баримталж, гүйцэтгэх захиралд хадгалагдсан асуудлыг зөв түвшинд шилжүүлэх; - Хямрал, саатал, маргаантай асуудлыг шуурхай зохицуулах.
	Багаар ажиллах	- Мэдээлэл, мэдлэгээ хуваалцаж, олон мэргэжлийн багийн хамтын ажиллагааг дэмжих; - Бусад газрын дарга, хэлтсийн удирдлагатай итгэлцэлд суурилсан ажил хэрэгч харилцаа тогтоох; - Саналын зөрүүг байгууллагын зорилго, нотолгоонд тулгуурлан зохицуулах; - Багийн амжилтыг дэмжиж, ажилтны оролцоо, санаачилгыг нэмэгдүүлэх.
	Бусад	- Төслийн удирдлага, стратегийн төлөвлөлт, гэрээ хэлэлцээ, эрсдэл болон тайлагналын баримт бичиг боловсруулах; - Орос эсхүл англи хэлээр мэргэжлийн харилцаа, хэлэлцээ хийх; - Дижитал төсөл удирдлага, мэдээллийн сан, удирдлагын тайлагналын хэрэгсэл ашиглах; - Төрийн албан хэрэг хөтлөлт, монгол хэл, найруулга зүйн өндөр чадвартай байх; - Байгууллага, төр, хувь хүний нууц болон ашиг сонирхлын зөрчлийн шаардлагыг чанд мөрдөх.

IV.ЭРХ ХЭМЖЭЭ, ШИЙДВЭР ГАРГАЛТ, ХАРИУЦЛАГА

Эрх хэмжээ:	**Үүрэг, хариуцлага:**
1. Гүйцэтгэх захирлын тогтоосон бодлого, чиглэл, эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааны нэгдсэн уялдааг хангах, бусад газрын дарга нарт үүрэг, чиглэл өгөх, хэрэгжилтийг хангуулах; 2. Төслийн удирдлагын газрын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалт, ажлын дараалал, нөөцийн хуваарилалтыг батлагдсан төлөвлөгөөний хүрээнд бие даан шийдвэрлэх; 3. Гүйцэтгэх захирлын тушаал, итгэмжлэл, эрх олголтын хүрээнд төрийн байгууллага, Газпром, CNPC болон бусад этгээдийн өмнө компанийг төлөөлөх, хамтарсан ажлын хэсэгт гишүүнээр оролцох;	1. АБТ, хөдөлмөрийн гэрээ, компанийн дүрэм, бодлого, журам болон гүйцэтгэх захирлын шийдвэрийг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх; 2. Компанийн хоёр дахь түвшний удирдлагын үүргийг хэрэгжүүлэхдээ эрх хэмжээний хязгаарыг баримталж, гүйцэтгэх захиралд хадгалагдсан асуудлыг дур мэдэн шийдвэрлэхгүй байх; 3. Худалдан авалт эхлүүлэх, гүйцэтгэгч сонгох, худалдан авах гэрээ байгуулах, төсөв батлах

4. Компанийн бүх газар, нэгж болон холбогдох талуудаас ажил үүрэгт шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлан, баримт бичгийг гаргуулан авах; 5. Нэгж хоорондын ажлын уулзалт зохион байгуулах, асуудал хэлэлцүүлэх, шаардлага хангаагүй ажлыг буцаах; 6. Төслийн хуваарь, төсөвт нөлөөлөх өөрчлөлт, техникийн шийдэл, эрсдэлийн арга хэмжээ, гэрээний үндсэн нөхцөл, ажил хүлээн авах, залруулах болон түр зогсоох асуудлаар гүйцэтгэх захиралд санал оруулах; 7. Эрх олгосон хүрээнд төслийн техникийн, зохион байгуулалтын, тайлангийн болон хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурах; 8. Газрын ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, сургалт, урамшуулал, албан тушаалын өөрчлөлт, сахилгын арга хэмжээний санал гаргах; 9. Газрын хүний нөөц, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ, санхүүжилтийн хэрэгцээ болон төсөв, худалдан авалтын санал боловсруулах; 10. Ажил үүрэгт хамаарах нууц болон хязгаарлагдмал мэдээлэлтэй тогтоосон журмын дагуу танилцах.	буюу өөрчлөх, төлбөр зөвшөөрөх шийдвэр гаргахгүй байх; 4. Төслийн стратеги, төлөвлөгөө, тайлан, санал, мэдээллийн үнэн зөв, бүрэн байдал, хугацаа болон мэргэжлийн үндэслэлийг хариуцах; 5. Төслийн ноцтой эрсдэл, хугацаа-өртөг-чанарын зөрүү, аюулгүй ажиллагааны нөхцөл, ашиг сонирхлын зөрчлийг нуун дарагдуулахгүйгээр шуурхай мэдээлэх; 6. Компанийн болон төслийн нэр хүнд, үндэсний эрх ашиг, гэрээний үүрэг, нууцлал, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах; 7. ХАБЭА, байгаль орчин, чанар, техникийн стандарт, зөвшөөрөл болон хууль эрх зүйн нийцлийг хангуулж ажиллах; 8. Албан тушаалын эрх мэдлийг хувийн болон бусдын ашиг сонирхолд ашиглахгүй, ёс зүй, шударга байдал, ашиг сонирхлын зөрчлийн шаардлагыг мөрдөх; 9. Буруутай үйл ажиллагаа, эс үйлдэхүйгээс компанид учруулсан хохиролд хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлага хүлээх; 10. Ажилтны гүйцэтгэл, ажлын сахилга, байгууллагын соёл, мэдлэгийн залгамж чанарыг газрын хэмжээнд хариуцах.
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолттой танилцсан ажилтан:
Албан тушаал: Хууль, хүний нөөцийн хэлтсийн дарга:/Г.Оюун/ ..... 2026 оны ..... сар .....өдөр	Албан тушаал Төслийн удирдлагын газрын дарга ..... 2026 оны ..... сар .....өдөр
Албан тушаалын тодорхойлолтыг хянасан: Захиргаа, удирдлагын газрын дарга:/Т.Батбилэг/ ..... 2026 оны..... сар .....өдөр	
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	

Байгууллагын нэр: "ЭРДЭНЭС ГАЗ" ХХК
Шийдвэрийн огноо: .....
Дугаар: .....

(тамга/тэмдэг)
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ /П.БАТАА/

УЛААНБААТАР ХОТ
ERDENES GAS
ЭРДЭНЭС ГАЗ ХХК
9026030560 6162401

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

“Эрдэнэс Газ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны 04 сарын 30-ны өдрийн 13 дугаар
тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
“Эрдэнэс Газ” ХХК	Төслийн удирдлагын газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Төслийн судалгаа, хөгжүүлэлтийн хэлтсийн дарга	-
Шууд удирдлага:	**Орлон болон хавсран ажиллах:**
Төслийн удирдлагын газрын дарга	-
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдөр 8 цаг	Монгол Улс, Улаанбаатар хот 14240 Сүхбаатар дүүрэг 1-р хороо, С.Жамъян Гүнгийн гудамж, 8-р байр, 301-3

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Төслийн удирдлагын газрын даргын шууд удирдлага дор байгалийн хий дамжуулах хоолойн төслийн стратеги, судалгаа, хөрөнгө оруулалтын үндэслэл, олон улсын хамтын ажиллагаа, гэрээ хэлцлийн бэлтгэлийг удирдан зохион байгуулж, нотолгоонд суурилсан санал, шийдвэрийн хувилбараар газрын даргыг хангах.

Албан тушаалын зорилт:

1. Төслийн судалгаа, хөгжүүлэлтийн бодлого, стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах.
2. Хөрөнгө оруулалт, санхүүгийн загвар, дотоодын хийн хэрэглээ, урьдчилсан ТЭЗҮ болон шийдвэрийн судалгааг удирдах.
3. Төслийн засаглал, гүйцэтгэл, стратегийн эрсдэл, мэдээлэл, тайлагналын дэмжлэг үзүүлэх.
4. Олон улсын хамтын ажиллагаа, хэлэлцээ, гэрээ хэлцлийн судалгаа, бэлтгэлийг зохион байгуулах.
5. Хэлтсийн хүний нөөц, гүйцэтгэл, мэдлэг, баримт бичиг, дотоод хяналтыг удирдах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	**Хариуцлага, оролцооны хэлбэр** Туслах–Т, Гүйцэтгэх–Г, Хянах–Х, Шийдвэрлэх–Ш, Санал оруулах–С
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Хэлтсийн жилийн болон дунд хугацааны судалгаа, хөгжүүлэлтийн төлөвлөгөөний төсөл боловсруулж, газрын даргаар хянуулах.	Төлөвлөгөө хугацаанд батлуулахаар хүргүүлсэн байдал	**Г/С**
	2. Төслийн стратеги, үе шат, засаглал, шийдвэрийн цэгийн хувилбар боловсруулж санал оруулах.	Саналын үндэслэл, шийдвэрт ашиглагдсан байдал	**Г/С**
	3. Газрын даргын чиглэлээр бизнес төлөвлөгөө, төслийн удирдлагын төлөвлөгөөний судалгааны хэсгийг боловсруулах.	Баримт бичгийн чанар, хугацаа	**Г**
	4. Судалгааны сэдэв, аргачлал, өгөгдлийн эх сурвалж, чанарын шалгуурыг тогтоож дотооддоо батлах.	Аргачлал мөрдсөн байдал	**Ш/Х**
	5. Судалгааны ажлын явц, үр дүн, зөрүүг хянаж залруулах арга хэмжээ авах.	Хугацаа, залруулгын биелэлт	**Х/Ш**
	6. Хэрэгжилтийн хэлтэс болон бусад нэгжтэй мэдээлэл, ажлын уялдаа, давхардалгүй байдлыг хангах.	Уялдаа, мэдээллийн бүрэн байдал	**Г/Х**
2 дугаар зорилтын хүрээнд	1. Дотоодын байгалийн хийн эрэлт, хэрэглэгч, салбар, бүс нутгийн зах зээлийн судалгааг удирдах.	Судалгааны хамрах хүрээ, шинэчлэлт	**Г/Х**
	2. Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн бүтэц, өгөөж, мэдрэмжийн шинжилгээний хувилбар боловсруулах.	Загварын үнэн зөв, хувилбарын чанар	**Г/С**
	3. Урьдчилсан ТЭЗҮ, бизнес кейс, хөрөнгө оруулалтын үндэслэл боловсруулах ажлыг зохион байгуулах.	Бэлэн байдал, шаардлага хангасан байдал	**Г/Х**
	4. Макро эдийн засаг, тариф, валют, санхүүжилтийн нөхцөлийн нөлөөллийг үнэлэх.	Таамаглалын үндэслэл, шинэчлэлт	**Г**
	5. Хувь нийлүүлсэн хөрөнгө, зээл, бусад санхүүжилтийн хувилбарыг харьцуулж санал боловсруулах.	Хувилбарын бүрэн байдал	**Г/С**
	6. Судалгаанд ашиглах өгөгдлийн сан, таамаглал, хувилбарын бүртгэлийг хөтлөх.	Мэдээллийн мөрдөх боломж, бүрэн байдал	**Г/Х**

	7. Судалгааны дүгнэлт, шийдвэрийн танилцуулгыг газрын даргад хугацаанд хүргүүлэх.	Тайлангийн хугацаа, ашиглагдсан байдал	Г
